

ТӨВ АЙМАГ-2010 ОНД

ТӨВ АЙМАГ-2010 ОНД

1. 2010 ондур тариа 82651 тн, төмс 50780 тн, хүнсний ногоо 11973 тн-ыг хураан авсан нь 2009 оноос үр тариа 22.4%, өмс 26.4%, хүнсний ногоо 8.9 хувиар тус тус өсч үр тарианы нэгжээс хураан авсан ургац, төмсний хураан авсан нийт ургацын хэмжээгээр улсдаа тэргүүлээ.



2. Жижиг дүүндвэрийг хөгжүүлэх сан байгуулахаар 2010 онд Сум бүрт 23.0 сая т өгрөгийн эх үүсвэрийг хуваарилж зээл олгон, 26 суманд “Өрхийн үйлдвэрлэлийн сан”-ийн эх үүсвэрийг 40 сая төгрөгт, Зуунмод суманд 114 сая төгрөгт хүрсэн.

3. Өв “Т аймгийг 2010-2016 онд үйлдвэржүүлэх төлөвлөгөө” -г хэрэгжүүлж Зуунмод сумын үйлдвэрлэл технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл, мастер төлөвлөгөөг батлав.

Сэргэлэн сумын нутаг Цагаан хярунд үйлдвэрийн парк байгуулах ажлын эхлэл тавигдаж, БНХАУ-ын 500.0 сая юаны хөрөнгө оруулалттай, жилд 1 сая тн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай Улаанцементийн үйлдвэрийн барилгын суурийн ажил хийгдэж байна.



4. Орон сууцны хангамжийг нэмэгдүүлж 2009-2010 онд Зуунмод хотод 38 айлын орон сууцны барилга, бага дунд орлоготой өрхийн 20 айлын орон сууц, шүүхийн ажиллагсдын 32 айлын орон сууц, Жөгжил хотхоны 132 айлын орон сууцны хотхонд 20 айл нэмж, Хуульчдын хотхонөслийн хүрээнд төрийн тусгай албан хаагчдын 12 айлын орон сууцыг шинээр барьж ашиглалтанд орууллаа.

5. Бүтээн байгуулалтын хүрээнд Халдвартын эмнэлэг, Спорт урлагийн цогцолбор байгуулав.



6. “Төв аймгийн эрдэмтдийн зөвлөл”-ийг 2010 онд байгуулан үйл ажиллагаагаа эхлэв.

“ТӨВ НУТГИЙН ХӨГЖИЛ, ЭРДЭМ СУДЛАЛ-1” залуу эрдэмтэн судлаачдын онол-практикийн бага хурлыг 2010 оны 12 дугаар сард зохион байгуулж, Аймгийн нийгэм, эдийн засгийн тэргүүлэх салбаруудын талаархи итгэл, мэдээлэл, хэлэлцүүлэг явууллаа.



7. Зуунмод хотын “Ирээдүй” цогцолбор цэцэрлэг, Ерөнхий боловсролын 4-р сургууль, Халдвартын эмнэлэгт Газрын гүний дулааны нөөцийг ашиглан дулааны эрчим хүчээр хангах шинэ дэвшилтэд технологи нэвтрүүлээ.

8. “Монгол туургатан” театр 2010 онд туурвисан “Харанхуй” үжиг болон хүүхдийн жүжгээрээ “Гэгээн Муза-2010” театр урлагийн 10 гаруй номинацийн эзэн болж, Гранпри шагнал хүртэв.



9. 2010 онд 67 сурагчид нисэх, усан онгоцны болон автомашины загварын, цахилгаан техникийн дугуйлангуудад, 12 сурагч гүнзгийрүүлэн мэдлэг чадвараа туршилтаар баталгаажуулан суралцаж байна.

Автомашин, нисэх болон усан онгоцны шинэ загвар хийж турших ажил зохиож, 13 удаа уралдаанд давхардсан тоогоор 249 сурагч оролцсон.

“ТӨВ АЙМАГ-2010” уран жолоодлогот нисэх

загварын төвийн бүсийн тэмцээн, Техник технологийн улсын 14 үдээр олимпиад зэрэг улсын чанартай уралдаан тэмцээн зохион байгуулж, 90 гаруй бүтээлээр үзэсгэлэн гаргав.

10. Орон нутгийн бүх түвшинд үйл ажиллагааны үр дүнд хийх Хяналт шинжилгээний арга зүйг боловсронгуй болгож, үнэлгээг бодит түвшинд ойртуулахад дэмжлэг үзүүлэн аймгийн ЗДТГ -ын харьяанд Дотоод аудит, Хяналт шинжилгээний албыг бие даасан байдлаар байгуулан ажиллуулав.